



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019.04.18 № 11

Асуулга тавих тухай

Монгол Улсын Эдийн Засгийн Хөгжлийн яамнаас 2014 онд “Кью Эс Си” компанитай “Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төсөл” хэрэгжүүлэх 30 жилийн гэрээг хийж, тус компанид Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн менежментийг явуулах эрхийг өгсөн байдаг. Дээрх гэрээ, гэрээний үр дүн, хэрэгжилтэнд хэрхэн хяналт тавьж ажиллаж байгаа талаар мэдээлэл ирүүлэх тухай Дархан-Уул аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн гарын үсэгтэй №616 албан тоотыг 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн.

Үүний хариуг Үндэсний хөгжлийн газраас 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн № 01/407 албан тоотоор ирүүлсэн. Ирүүлсэн хариуд гэрээний хэрэгжилт, үр дүн болон төмрийн хүдрийн экспортын талаар хангалттай мэдээлэл дурьдаагүй байсан.

Иймд бидний зүгээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг танд тавьж байна.

1. “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ”- ний хэрэгжилтэнд Засгийн газраас хэрхэн хяналт тавьж ажиллаж байгаа вэ?
2. Гэрээний хэрэгжилтийн үр дүн, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг өгнө үү;
3. Гэрээ хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хэдийн хэмжээний хүдэр олборлож, гэрээний ямар зүйл заалт болон бусад ямар зөвшөөрлийн хүрээнд хичнээн тонн төмрийн хүдрийг экспортоор гаргасан бэ? /он, сараар/
4. Нийт экспортын орлогын зарцуулалт болон үндсэн төсөлдөө оруулсан хөрөнгө, мөн улс, орон нутгийн төсөвт ямар хэмжээний орлого оруулсан талаарх мэдээлэл өгнө үү;
5. Энэ гэрээг цаашид хэрхэх талаар Засгийн газрын байр суурийг сонсохыг хүсэж байна.

Асуулгын хариуг Монгол улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсохыг хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд

Хүндэтгэсэн ,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЖАВХЛАН
Б.БАТТӨМӨР
Д.ХАЯНХЯРВАА